



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг шагнаж, урамшуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны А/214 дүгээр тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ зохих ёсоор биелүүлэн, 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хангаж ажилласан оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийг “Өргөмжлөл”, “мөнгөн шагнал”-аар тус тус шагнаж урамшуулсугай.

2. 2021 оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа С.Батбаямба/-т зөвшөөрсүгэй.



4. Шагнагдсан хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн удирдлага, бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, ажлын амжилт хүссүгэй.

5. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуул.

ДАРГА, ХУРАНДАА

Д.ЗАГДЖАВ

